



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/977

Мандалговь

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх  
хяналт тавьж ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15, 16 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт малын гоц халдварт шүлхий өвчин гарсан тул шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналтын пост гаргаж ажиллуулахыг сумдын Засаг дарга, онцгой комиссын дарга нарт даалгасугай.

2. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин гарсан хөрш зэргэлдээ аймаг, сумдаас малын худалдаа, шилжилт хөдөлгөөн, мал тээвэрлэлт хийх үйл ажиллагаа болон мал, амьтны гаралтай түүхий эд, мах махан бүтээгдэхүүнд тавих хяналт шалгалтыг чангатгаж, малын гарал үүслийн гэрчилгээ, мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн дэглэмийг чанд мөрдүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар, Хүнс, Хөдөө аж ахуйн газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Гадны аймгуудад отор нүүдлээр нүүдэллэж байгаад орон нутагтаа ирж буй малын шилжилт хөдөлгөөн ихсэж байгаатай холбогдуулан гоц халдварт болон халдварт өвчтэй бүс нутгаас эрүүл бүс рүү мал орж ирэхээс урьдчилан сэргийлэх, малд эрүүл мэндийн үзлэг хийж, мал эмнэлэг, ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээг шалгаж орон нутагт нь нэвтрүүлэх, өвчний сэжигтэй бүс нутгаас мал оруулахгүй байхыг Хүнс, Хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Цагдаагийн газар, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Өөрийн сумын малчдад шүлхий өвчний талаар урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэж, малд тандалт судалгаа, эрүүл мэндийн үзлэг хийж өвчний сэжиг илэрсэн үед баталгаажих хүртэл өвчний халдварыг голомтод хязгаарлалт, хорио цээрийн дэглэм тогтоох, өвчтэй малыг ялган тусгаарлах, устгах, булшлах, халдваргүйжүүлэх зэрэг арга хэмжээг холбогдох хууль, дүрэм, зааврын дагуу шуурхай авч хэрэгжүүлэхийг сумдын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210320